

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.12.22

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Гадаад худалдааны тэнцэл 477.6 сая ам.долларын ашигтай гарлаа
- Нүүрсний үнэ хямд байгаа нь төлбөрийн тэнцлийг эрсдэлд оруулж байна
- Премиум Нэксус хк: хувьцаа буцаан худалдан авах эрхийн хугацаа дуусахад 1 хоног үлдлээ

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	1.93%	0.92%	25.47%
MSE A	2.74%	-0.01%	20.27%
MSE B	-4.17%	-0.97%	34.89%

2025/12/15 – 2025/12/19

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
GLMT	27,912,432,425.00
INV	7,184,422,260.00
KHAN	1,219,449,088.00
APU	393,650,877.67
RMC	390,018,582.00

2025/12/15 – 2025/12/19

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
ERS	19,550.00	23.81%
MIK	16,850.00	21.22%
OLL	74.12	17.19%
BAN	1,955.00	15.00%
HBZ	3,140.00	14.98%

2025/12/15 – 2025/12/19

2025 он 12-р сарын 22

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,533

ТОП-20 индекс

53,127

MSE A

20,319

MSE B

14,052

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

8.2%

2025-11 сар

ГВУН(сая\$)

5,886.14

2025-11 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,544.81

2025-12-14

 **Эдийн засгийн мэдээлэл****ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ 477.6 САЯ АМ.ДОЛЛАРЫН АШИГТАЙ ГАРЛАА**

Монгол Улсын гадаад худалдаа 2025 оны эхний 11 сарын байдлаар 24 тэрбум ам.долларын бараа эргэлттэй байж, өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар өссөн байна. Экспортын орлого 13.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 3.1 тэрбум ам.доллараар буурсан үзүүлэлттэй гарчээ. Харин импортын хэмжээ 12.1 тэрбум ам.доллар болж, мөн адил буурсан байна. Үүний үр дүнд гадаад худалдааны тэнцэл 477.6 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оноос харьцангуй буурсан үзүүлэлт юм.

Экспортын бүтэц

Экспортын орлогын дийлэнх хэсгийг эрдэс бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Тодруулбал:

- Зэсийн хүдэр, баяжмал – 36.9%
- Чулуун нүүрс – 35.6%
- Алт – 7.1%
- Төмрийн хүдэр, баяжмал – 4.2%

Эдгээр нэр төрлийн бүтээгдэхүүн нийт экспортын орлогын 85.6 хувийг эзэлж байгаа нь Монгол Улсын экспортын бүтэц түүхий эдээс өндөр хамааралтай хэвээр байгааг харуулж байна.

Импортын голлох нэр төрлүүдэд:

- Газрын тосны бүтээгдэхүүн
- Суудлын автомашин
- Хүнсний зарим нэр төрлийн бүтээгдэхүүн багтсан бөгөөд нийт импортын дүн буурсан нь дотоодын эрэлт, хөрөнгө оруулалтын идэвхтэй холбоотой байж болзошгүй гэж шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НҮҮРСНИЙ ҮНЭ ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙГ ЭРСДЭЛД ОРУУЛЖ БАЙНА

Манай улсын экспортын орлогын гол эх үүсвэр болох нүүрсний үнэ сэргэх шинж хараахан ажиглагдахгүй байна. 2025 оны 9-р сарын байдлаар чулуун нүүрсний үнэ тонн тутамд 61.4 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 37.1 хувиар буурчээ. Үүнд БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт, тарифын шийдвэрүүдийн нөлөөгөөр коксжих нүүрсний эрэлт суларсан нь голлон нөлөөлж байна. Ийм нөхцөл байдал үргэлжилбэл нүүрсний үнэ цаашид ч буурч, экспортын болон төсвийн орлогод сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Нүүрсний үнийн уналт нь төлбөрийн тэнцэлд дарамт учруулж байна. Дэлхийн худалдааны зөрчил, геополитикийн тодорхой бус байдал, мөн БНХАУ-ын үл хөдлөх салбарын хүндрэлээс шалтгаалан нүүрсний үнэ сүүлийн жилүүдэд ерөнхийдөө доошлох хандлагатай байна. Тухайлбал, 2025 оны 9 дүгээр сарын байдлаар манай нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оноос 36.3 хувиар буурсан байна. Үүнтэй зэрэгцэн оны эхний хагаст экспортын биет хэмжээ багассан нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлжээ.



Зах зээлийн мэдээлэл

ПРЕМИУМ НЭКСУС ХК: ХУВЬЦАА БУЦААН ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙН ХУГАЦАА ДУУСАХАД 1 ХОНОГ

Премиум Нэксус ХК нь 2025 оны гуравдугаар улиралд санхүү болон үйл ажиллагааны үзүүлэлтүүдээ тогтвортой сайжруулж, урт хугацааны өсөлтөд чиглэсэн стратегиа бодитоор хэрэгжүүлж буйгаа харуулсан. Компанийн борлуулалтын орлого сүүлийн таван жилд жилд дунджаар 72 хувиар өсөж, 2024 оны эцэст 598 тэрбум төгрөгт хүрсэн бол 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 587.1 тэрбум төгрөгийн борлуулалттай явж байна. Үүний үр дүнд нийт ашиг 112.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 39.6 хувиар, ХТЭББӨА 76.4 тэрбум төгрөгт хүрч 20 хувиар өссөн нь компанийн үндсэн үйл ажиллагаа тогтвортой, үр ашигтай байгааг илтгэнэ. Нийт ашгийн маржин 19.2 хувь болж 0.6 нэгж хувиар нэмэгдсэн нь бүтээгдэхүүний бүтэц, үйл ажиллагааны менежмент сайжирсныг харуулж байна.

Нөгөө талаас, сүлжээний өргөтгөл, дижитал систем болон логистикийн шинэчлэлд хийсэн идэвхтэй хөрөнгө оруулалтын улмаас үйл ажиллагааны зардал 36.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс огцом өссөн нь цэвэр ашгийн өсөлтийг богино хугацаанд сааруулж, 26.39 тэрбум төгрөгт хүрэхэд нөлөөлжээ. Гэвч энэ нь ашиг бууралт бус, харин ирээдүйн өсөлтийг бэлтгэж буй хөрөнгө оруулалтын үе шат гэдгийг балансын үзүүлэлтүүд баталж байна. Нийт хөрөнгө 408.5 тэрбум төгрөг болж 30.1 хувиар, өөрийн хөрөнгө 131.1 тэрбум төгрөг болж 27.6 хувиар тус тус өссөн бол хуримтлагдсан алдагдал 21.3 тэрбум төгрөгөөр буурч, санхүүгийн бүтэц мэдэгдэхүйц сайжирсан байна.


Үйл ажиллагааны хувьд компанийн СУ дэлгүүрийн тоо 515-д хүрч, оны эхнээс 70-аар нэмэгдсэн бөгөөд өдөр тутмын хэрэглэгчдийн тоо 220 мянга давж, нэгж дэлгүүрийн дундаж борлуулалт өссөн нь өсөлт зөвхөн тоон тэлэлт бус, нэгжийн гүйцэтгэл, хэрэглэгчийн урсгалыг оновчтой удирдаж байгааг харуулж байна. Мөн охин компаниудын үйлдвэрлэл, маркетинг, олон улсын стандарттай уялдсан хөгжлийн үр дүн бодитоор гарч, 2025 оны есдүгээр сард Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд шилжсэн нь компанийн ил тод байдал, засаглалын түвшин шинэ шатанд гарсныг илтгэж байна.

Олон улсын зах зээлийн практикт өсөлтийн шатанд буй компаниуд богино хугацаанд ногдол ашиг тараахаас илүүтэйгээр ашиг болон мөнгөн урсгалаа дэд бүтэц, үйл ажиллагааны өргөтгөл, технологи, зах зээлийн тэлэлтэд дахин хөрөнгө оруулах нь түгээмэл байдаг. Энэ нь компанийн ирээдүйн өсөлт, орлогын тогтвортой эх үүсвэрийг бэхжүүлж, урт хугацаанд хувьцааны өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой стратеги юм. Хөрөнгө оруулагчдын хувьд богино хугацааны ногдол ашгаас илүүтэйгээр ирээдүйн үнэ цэнэ, өсөлтийн чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарч байна гэж дүгнэгддэг. Тиймээс Премиум Нэксус ХК нь олон улсын зах зээлийн практикийг дагавал ногдол ашиг тараах нь тодорхой хугацаанд хойшлогдохоор харагдаж байна.

Премиум Нэксус ХК-тай холбоотой онцлох мэдээг дурдвал, компанийн ТУЗ-өөс 2025 оны 11 дүгээр сарын 7-нд хувьцаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан бөгөөд үүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчид уг эрхээ 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүртэл хэрэгжүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, хувьцаагаа худалдахыг шаардах эрхийн хугацаа дуусахад ердөө 1 хоног үлдсэн нь хөрөнгө оруулагчдын хувьд богино хугацаанд анхаарал хандуулах чухал мэдээлэл болж байна.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

